



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 3/09

Жаргалтхаан сум

Г.Түмэнжаргалд сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.1.2, Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 36/32 дугаартай тушаалаар батлагдсан "төрийн жинхэнэ албан хаагчид санхилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.5, 1.5.2, 3.1, 3.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ажлын цагаар архи согтууруулах ундаа хэрэглэж, төрийн албыг цалгардуулж, хүндэтгэн үзэх шалгаангүйгээр ажил тасалж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ биелүүлээгүй Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Ганболдбаатарын Түмэнжаргалд үндсэн цалинг нэг сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Цаашид холбогдох хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ цаг хугацаанд нь хариуцлагатай биелүүлж, төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөж явах, идэвх санаачилгатай ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Ганболдбаатарын Түмэнжаргалд үүрэг болгосугай.

3.Сахилгын шийтгэлийг 2026 оны 4 дүгээр сарын цалингаас тооцож суутгахыг нягтлан бодогч Т.Энхсайханд даалгасугай.

ДАРГА



С.МӨНХДЭЛГЭР